

## **НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

- 1.1. Энэхүү журмаар НССДС-ийн Хөтөлбөрийн хорооны зорилго, баримтлах зарчим, бүтэц, зохион байгуулалт, тавигдах шаардлага, чиг үүрэг, үйл ажиллагаа, хөтөлбөрийг хэлэлцэж батлахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2. Хөтөлбөрийн хорооны үндсэн зорилго нь дээд боловсрол олгох сургалтын нийтлэг шаардлагын хүрээнд шинжлэх ухаан, технологийн ололт дэвшил, нийгмийн болон салбарын эрэлт хэрэгцээнд тулгуурласан, мэргэжлийн өргөн бөгөөд гүнзгий мэдлэг, үр чадвартай, бие даан тасралтгүй хөгжих чадамжтай мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах, хөтөлбөрт мэргэжлийн экспертиз хийх, зохих шийдвэр гаргахад оршино.
- 1.3. Хөтөлбөрийн хороо нь Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батлан гаргасан эрх зүйн акт болон энэхүү журам, бусад холбогдох журмыг үйл ажиллагаандаа мөрдөнө.
- 1.4. Хөтөлбөрийн хороо нь хууль дээдлэх, уламжлал, шинэчлэл, хөгжлийн бодлого, дээд боловсролын агуулга, үзэл баримтлалыг хангах, шинжлэх ухаанч, мэргэжлийн байр сууринаас хандах, хараат бус, ил тод, нээлттэй, хүртээмжтэй, ёс зүйтэй байх зарчмыг үйл ажиллагаандаа баримтлана.
- 1.5. Хөтөлбөрийн хороо нь байнгын бус үйл ажиллагаатай байх бөгөөд Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааны тасралтгүй байдлыг Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын алба /ХЧБА/ хангаж ажиллана.

### **Хоёр. Хөтөлбөрийн хорооны чиг үүрэг**

- 1.1. Хөтөлбөрийн ерөнхий хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 1.1.1. Боловсролын талаарх төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, хөтөлбөрийн стандарт шаардлага, НССДС-ийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтын хүрээнд тухайн мэргэжлийн бакалаврын сургалтын хөтөлбөрийг боловсруулж Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх, захирлын тушаалаар батлуулах, холбогдох асуудлаар санал оруулах;
  - 1.1.2. Сургуулийн стратеги төлөвлөгөө, дээд боловсролын олон улсын хөгжлийн хандлага, мэргэжлийн ирээдүйн чиг баримжаа, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, практик, үр чадварт суурилсан арга зүйд үндэслэн сургалтын хөтөлбөрт шаардлагатай бол нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэ хөтөлбөрүүд боловсруулах;
  - 1.1.3. Сургалтын хөтөлбөрт 3 жил тутам иж бүрэн үнэлгээ хийх, Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн өөрийн үнэлгээний тайланг боловсруулах;
  - 1.1.4. Сургуулийн хэмжээнд бүх сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага, боловсруулах арга зүй, хөтөлбөрийн үнэлгээ хийх, үйл ажиллагаанд баримтлах удирдамжийг багтаасан журам боловсруулан захирлаар батлуулах, хэрэгжүүлэх;

### **Гурав. Хөтөлбөрийн хорооны бүтэц, зохион байгуулалт, хуралдаан**

- 3.1. Хөтөлбөрийн хороо нь дарга, гишүүдээс бүрдсэн 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд захирал 5 жилийн хугацаатай томилно.
- 3.2. Хөтөлбөрийн хорооны гишүүд нь дээд боловсролын бодлого, их сургууль, шинжлэх ухааны байгууллагуудын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны зохих мэдлэгтэй, тухайн мэргэжлийн хөтөлбөрийн чиглэлээр экспертиз үнэлгээ хийх чадвартай, ашиг сонирхлын зөрчилгүй, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх шаардлагыг хангасан байна.
- 3.3. Хөтөлбөрийн хорооны даргаар ХЧБА-ны менежер, нарийн бичгийн даргаар мэргэжлийн тэнхимийн эрхлэгч, гишүүдээр Сургалтын албаны менежер, ХЧБА-ны мэргэжилтэн болон тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн судлаач, эрдэмтэн, багш, тухайн мэргэжлээр төгссөн төгсөгчийг томилно. Шаардлагатай бол ажил олгогчийн болон мэргэжлийн холбоо, нийгэмлэгийн төлөөллийг нэмж оруулж болно.
- 3.4. Хөтөлбөрийн хорооны ажлын үр дүн, тайлан үзүүлэлтийг жил бүр дүгнэж, гишүүдийг үргэлжлүүлэн ажиллуулах, өөрчлөх асуудлыг захирлын тушаалаар шийдвэрлэнэ.
- 3.5. Хөтөлбөрийн хорооны гишүүдийг жилд 1 удаа чадавхжуулах сургалт, семинар, туршлага судлах үйл ажиллагаанд сургуулиас хамруулна.
- 3.6. Хөтөлбөрийн хороодын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал бөгөөд гишүүдийн 75 хувиас доошгүй ирцтэй тохиолдолд хурлыг хүчинтэйд тооцож, хэлэлцсэн асуудлаар олонхийн саналаар шийдвэр гаргаж, хурлын тэмдэглэл хөтөлнө.
- 3.7. Хөтөлбөрийн хорооны хурлыг жилд 2-оос доошгүй удаа хийнэ. Хөтөлбөрийн хорооны дарга хурлаар хэлэлцэх асуудлыг томьёолж, хуралдах товыг тогтоож, хурлыг даргалан явуулна. Зайлшгүй тохиолдолд ээлжит бус хурлыг Хөтөлбөрийн хорооны даргын шийдвэрээр хуралдуулж болно.
- 3.8. Хөтөлбөрийн хороодын нарийн бичгийн дарга хэлэлцэх асуудлаар мэдээлэл, материалыг бүрдүүлэн, гишүүдэд хүргэх, гарсан шийдвэр, зөвлөмж, экспертиз, тэмдэглэл болон бусад албан баримт бичгийн мэдээллийн сан үүсгэж хадгална.
- 3.9. Хөтөлбөрийн хорооны хурлын шийдвэр нь тогтоол байна. Хөтөлбөрийн хорооны тогтоолд хорооны дарга, хурлын тэмдэглэлд нарын бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд тусгайлан байгуулсан ажлын хэсэг, хөндлөнгийн байгууллага, мэргэжлийн шинжээчдийн дүгнэлт, саналыг хурлын тэмдэглэл, шийдвэрт тусгана.

### **Дөрөв. Журмын хэрэгжилт, хяналт шинжилгээ**

- 4.1. НССДС-ийн Эрдмийн зөвлөл, Захирлын зөвлөл, Сургалтын алба, тэнхим, бусад нэгжүүд нь Хөтөлбөрийн хорооны үйл ажиллагааг дэмжин ажиллана.
- 4.2. ХЧБА нь Хөтөлбөрийн хорооны хурал хоорондын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хэрэгжүүлэн ажиллах бөгөөд хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудал, шийдвэрийн төслийг урьдчилан боловсруулах, хянах үүрэг хүлээх бөгөөд сургалтын хөтөлбөрүүдийн хэрэгжилт, хяналт, үнэлгээг мэргэжлийн тэнхимтэй хамтран хариуцан гүйцэтгэнэ.
- 4.3. Хөтөлбөрийн хороо нь хөтөлбөрийн хяналт шинжилгээ, үнэлгээг нийт хөтөлбөрүүдээс түүвэрлэн сонгож, хөндлөнгийн хараат бус мэргэжлийн байгууллагаар хийлгэж болно.

### **Тав. Бусад зүйл**

- 5.1. Ажлын үр дүнд үндэслэж Хөтөлбөрийн хорооны гишүүдэд хичээлийн жилд нэг удаа 500,000 төгрөг хүртэлх хэмжээний мөнгөн урамшууллыг захирлын тушаалаар олгоно.
- 5.2. Журмаар зохицуулагдахгүй харилцааг Эрдмийн зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэнэ.

**НИЙГЭМ, СЭТГЭЛ СУДЛАЛЫН ДЭЭД СУРГУУЛИЙН  
ХӨТӨЛБӨРИЙН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН**

Нэг. Хорооны дарга:

1. Хөтөлбөр, чанарын баталгаажуулалтын албаны менежер

Хоёр. Хорооны гишүүд:

2. Сургалтын албаны менежер
3. Тухайн мэргэжлийн тэнхимийн эрхлэгчид
4. ХЧБА-ны мэргэжилтнүүд
5. Тухайн мэргэжлийн чиглэлээр мэргэшсэн судлаач, эрдэмтэд
6. Тухайн мэргэжлээр төгссөн төгсөгч